

"ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ"-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
/2019 оны 1 дүгээр улирлын байдлаар/

2019.03.28

Булган аймаг

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1. ИРГЭДИЙН ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ							
1	1.1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан иргэн төвтэй "ухаалаг үйлчилгээ"-г хөгжүүлэх	1.1.1. Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж, Төрийн цахим мэдээлэл солилцооны системд төрийн байгууллагуудыг холбох үйл ажиллагааг эрчимжүүлж, цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх;	IV		Төрийн 35 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	ХТХБ
2		1.1.3. Орон нутгийн иргэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлж, 7 сумыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд шинээр холбох;	III		16 сум, 1 тосгонд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэх	Аймгийн 16 сум, 1 тосгон өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд бүрэн холбогдсон. Сумд, байгууллагууд төрийн албан хэрэгцээний цахим программыг бүрэн ашиглаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газар, Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй "Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох" төслийн хүрээнд 8 сумыг нэгдсэн сүлжээнд холбох бөгөөд, үлдсэн сумдыг төсвийн хөрөнгөөр холбохоор бэлтгэлийг хангаж байна.	70
3		1.1.4. Төрийн үйлчилгээний "Цахим үйлчилгээний төв"-ийг орон нутагт байгуулах;	IV		Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний "Цахим төв"-ийг нэвтрүүлэх	Төрийн үйлчилгээний нэгдсэн "Цахим төв"-ийг байгуулах саналыг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн.	30
4		1.2.1. Төрийн үйлчилгээний албан ёсны жагсаалтыг гарган, төрийн үйлчилгээний стандартыг боловсруулах;	IV		Төрийн үйлчилгээний албан ёсны жагсаалтыг гаргасан байна	Хугацаа болоогүй үнэлэх боломжгүй байна.	ХТХБ
5		1.2.2. Төрөөс үзүүлдэг үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний байгууллага бүр тоо хэмжээ, цаг хугацаа, чанар, өртөг гэсэн үзүүлэлтээр үйлчилгээний стандарт тогтоож хэрэгжүүлэх;	IV		Хэрэгжилтийг хангаж ажиллах	Иргэний үнэмлэх, гадаад паспорт захиалах үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхээр бэлтгэлийг хангаж байна.	30

6	1.2. Иргэдийн хэрэгцээнд суурилсан төрийн үйлчилгээний стандартын тогтолцоог хөгжүүлэх	1.2.3. Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжинд шилжүүлэх;	III		Аймгийн хэмжээний бүх сургууль 2 ээлжээр хичээллэдэг болсон байна.	Боловсролын салбарт сүүлийн 3 жилд нийт 11.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. 2017 онд Булган сумын 150 хүүхдийн цэцэрлэг, 2018 онд 1280 суудалтай сургуулийн 2 шинэ барилгыг ашиглалтад хүлээн авлаа. Аймгийн хэмжээнд 22 сургууль байгаагаас Хутаг-Өндөр сумын сургуульд 1-р ангийн бүлгүүд гурван ээлжээр хичээллэж байна. Иймд 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хичээлийн байрны барилгын өргөтгөл баригдаж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Тэшиг сумын сургуулийн хүүхдийн тооны өсөлтийн хэтийн төлөв нь 2019-2020 оны хичээлийн жилд 3-4 бүлэг 3 ээлжинд хичээллэх нөхцөл байдал үүсээд байна. Тэшиг сумын сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийн барилгын ажил хөрөнгө санхүүгээс шалтгаалан зогссон байгаа бөгөөд нэн даруй барилгын ажлыг гүйцээж, улсын комисст хүлээлгэн өгөх шаардлагатай байна.	70
7	1.2. Иргэдийн хэрэгцээнд суурилсан төрийн үйлчилгээний стандартын тогтолцоог хөгжүүлэх	1.2.4. Сурагчид дотуур байрандаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээ бий болгох;	IV		ЕБС-ийн дотуур байрны эрүүл ахуй, орчны үйлчилгээг сайжруулж, стандарт хангагдсан байна.	Аймгийн хэмжээнд нийт 26 дотуур байр байгаагаас стандарт хангасан 22 байр байна. Үүнээс инженерийн шугам сүлжээнд холбогдсон 10, нам даралтын уурын зуухтай 16 байр байна. 2018-2019 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд нийт 1867 хүүхэд дотуур байранд амьдрах хүсэлт гаргаснаас 1775 хүүхэд хамрагдаж байна. Дашинчилэн, Рашаант сумд, Хялганат тосгоны сургуулийн дотуур байрыг шинээр барих барилгын зураг төсөв хийгдсэн. Үүнээс Рашаант суманд баригдах дотуур байрны барилгын ажлын 1.1 тэрбум төгрөгийн төсөв шийдэгдэж, барилгын ажил энэ онд хийгдэнэ. Бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээ бий болгох чиглэлээр сумдын сургуулиуд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан дотуур байрны өрөө тасгийг гэрийн нөхцөлд ойртуулан тохижуулах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж байна. Тухайлбал: Орхон сумын сургуулийн дотуур байр төгсөгчид, малчидтай хамтран бүх тасгаа тохижуулаад байна. Цаашид дотуур байрны хатуу зөөлөн эдлэл, бусад тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	70
8	1.2. Иргэдийн хэрэгцээнд суурилсан төрийн үйлчилгээний стандартын тогтолцоог хөгжүүлэх	1.2.5. Ахлах сургуулийн сурагчид сургуулиа төгсөөд сурах их дээд сургууль, мэргэжлээ зөв сонгох, элсэн суралцах бэлтгэлийг хангах талаар ажил мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх;	IV		Ахлах ангийн сурагчид мэргэжлээ зөв сонгох, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээнд хамрагдсан байна. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь хэрэгжсэн байна.	2019 онд элсэлтийн ерөнхий шалгалтад 255 сурагч оролцохоор бүртгүүлсэн бөгөөд бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний дагуу тандах шалгалтыг 4 удаа зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл"-ийн хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилд 10-12 ангийн сурагчдад "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" сургалтыг ерөнхий боловсролын сургуулиуд 7 хоног бүр зохион байгуулж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2019 оны 03 дугаар сарын 22-нд "Эерэг хандлага, хөгжил" сэдэвт лекц сургалтад 9-12 дугаар ангийн 210 суралцагч хамрагдсан.	100

9	1.3. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний менежментийг сайжруулах хөтөлбөрийг салбар бүр хэрэгжүүлэх	1.3.1. Байгууллага бүр үйлчилгээний менежментийг сайжруулах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;	I y		Байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж сайжруулах төлөвлөгөө боловсруулсан байна	Аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгоны Засаг даргын Тамгын газар болон төр, төсвийн байгууллагууд үйлчилгээний чанар хүртээмжийн сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай хүргэх зорилгоор "Угтах үйлчилгээ"-г нэвтрүүлсэн. Байгууллага бүр улирал тутам "Хүлээж суулгүй, хүрч үйлчилье" нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээллийг иргэдэд хүргэж байна.	70
10		1.3.2. Үйлчлүүлэгчтэй харилцах нэгжийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан бэхжүүлж, үйлчилгээний ажилтан, менежерийг чадавхжуулах, холбогдох сургалтад хамруулах;	IV		Сургалтад хамрагдсан байна	2019 оны эхний улирлын байдлаар 16 сум, 1 тосгон, 22 агентлаг, төр төсвийн байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт ажлын байрны шинжилгээ хийх, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх сургалтыг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 680 албан хаагчийг хамрууллаа.	30
11	1.4. Зорилтот бүлэгт чиглэсэн төрийн үйлчилгээг хөгжүүлэх	1.4.1. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний стандартыг боловсронгуй болгох;	IV		Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах, холбогдох бусад стандартыг батлуулан мөрдөж эхлэх	2019 оны эхний улирлын байдлаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрт хамруулах, жижиг зээлээр дэмжин ажлын байрыг бий болгох зорилгоор төсөл, хөтөлбөрийн танилцуулга мэдээллийг 30 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хийж эхлээд байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд зориулсан зам тээврийн дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээний бусад барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үзлэг шалгалт зохион байгуулахаар ажлын хэсгийг томилоод байна.	30
12		1.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхдагч мэдээллийн сан байгуулах	IV		Мэдээллийн санг жил бүр шинэчлэн бүрдүүлсэн байна	Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй нийт 2390 иргэн байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 441 хүүхэд байгаа бөгөөд тэдгээрийн 154 нь байнгын асаргаа шаардлагатай байна. Тус мэдээллийн санг улирал тутам шинэчлэн баяжуулж үйл ажиллагаандаа ашиглаж хэвшив. Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгааныг судалж үзэхэд оюуны болон сэтгэцийн өвчин, ахуйн ослоос үүдэлтэй гэмтлийн өвчлөл зонхилж байна. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн бүртгэлийг Өрхийн эмнэлгийн 8 дугаар маягтаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж, Өрхийн эмнэлгийн 9 дүгээр маягтаар "Ахиц дэвшлийн үнэлгээ"-нд бүрэн хамруулсан. Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь авч үзвэл: харааны 317, сонсгол 202, хэл, ярианы 83, хөдөлгөөний 468, зан үйл, сэтгэцийн 336, хавсарсан 181, бусад 495, нийт 2082 иргэний судалгааг гаргаж, мэдээллийн санд бүртгүүлээд байна. Харин аймгийн ЭХМК-ын судалгаагаар 2012 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцэж сунгасан-1376 хүн, шинээр тогтоосон-298 хүн, цуцалсан-293 хүн, хөдөлмөрийн чадвар алдалтыг заалтад тохирохгүй үндэслэлээр шийдвэрлэх шаардлагагүй буцаасан-45, оршин суугаа харьяалал шилжиж явсан-10 хүн, бусад аймаг, дүүргээс шилжиж ирсэн-10 хүн, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь нь өссөн-171 хүн, хувь нь буурсан-131 хүн байна. Дээрх судалгааг жил бүр шинэчлэн гаргаж байна.	100

13		1.4.5. Зорилтот бүлгийн хөгжил, амьжиргааны түвшний талаар цахим мэдээллийн сан бий болгож, тэдгээрийн хэрэгцээ, ур чадварт нийцүүлэн нийгмийн халамжийн дэмжлэг, үйлчилгээг үзүүлэх;	IV	Аймгийн төсөв 17.0 сая төгрөг	Судалгаа хийгдэж дүгнэлт гарсан байна	Аймгийн хэмжээнд хөтөлбөрт хамруулахаар сонгосон зорилтот өрхийн нөхцөл, байдлыг үнэлэхээр ажлын хэсэг томилон айл өрх бүрийг судлан, дүгнэлт гаргахаар ажиллаж байна. Тус судалгааны дүнд тулгуурлан зорилтот өрхийн гишүүн болон тухайн өрхийн бусад гишүүдийн хүсэлтийг үндэслэн өрхийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнийг шаардлагатай асрамжийн үйлчилгээнд хамруулах, бусад гишүүдийг ажил эрхлэх, олон нийтийн арга хэмжээнд оролцоход дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэ арга хэмжээнд зориулж аймгийн төсвөөс 17.0 сая төгрөг зарцуулна.	30
14	1.6. Төрийн үйлчилгээг удирдах, хянах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	1.6.1. Нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг төрийн зарим байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог бий болгох;	IV		Нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагууд жилд 4 доошгүй хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдийн оролцоог хангах	Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлд ажил олгогч, Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчид оролцож, хийж хэрэгжүүлж байгаа ажил, үйлчилгээнд хамтран ажиллах, санал хэлэлцэх, хяналт тавих зэргээр ажиллаж байна. Мөн ХНЗ-ийн 3 талт хэлэлцээр, ХАБЭА-н салбар хороо, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах аймгийн салбар хороо зэрэг 10 гаруй салбар комисст иргэдийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг бүрэн оролцуулж байна. Мөн аймгийн ИТХ-аас 2019 оныг "Ахмадын хөгжлийг дэмжих жил" болгон зарлаж, иргэний танхимаар хэлэлцүүлэг зохион байгуулж, 170 гаруй ахмад настныг хамруулан жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал авлаа. Мөн "Залуучуудын хөгжлийг дэмжих жилийн аян"-ы хүрээнд 250 гаруй залуучуудын уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал авч нэгтгэн төлөвлөгөө боловсруулан ажиллаж эхлээд байна. Үүнээс гадна аймгийн ЭХМК, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисст хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулан цалин урамшуулал олгон ажиллаж байна.	70
2. ИЛ ТОД БАЙДАЛ, ИРГЭНИЙ ОРОЛЦООТОЙ ШИЙДВЭР ГАРГАЛТ							
15	2.1. Шийдвэр гаргах үйл явцыг ил тод болгож, иргэдийн оролцоог хангах	2.1.1. Бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж, мэдээлэл ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх;	IV		Иргэдийн цахим оролцооны индексийг нэмэгдүүлсэн байна	2019 оны эхний улирлын байдлаар бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж, мэдээллийг ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлаар Иргэний танхимаар ахмадын жилийн төлөвлөгөөг батлах тухай, Нийтийн эзэмшлийн гудамж талбайд мод тарьсан иргэнийг урамшуулах журмыг шинэчлэх тухай, Ойжуулалт хийх ойн зурвас байгуулах газрын тухай, Цагдаагийн газрын 2018 оны үйл ажиллагааны тайлан, Ахмадын сан байгуулах тухай, Уул уурхайн бодлогын тухай, Сайн хөрш хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай, Усан спорт сургалтын төвийн үнэ тариф, спорт залны түрээсийн тухай, Архи согтууруулах ундаа худалдан борлуулах цэгийн төлбөр төлөх журмын тухай, Боловсролын салбарын ил тод байдал эгэх хариуцлага төслийн үр дүнгийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн тухай зэрэг 13 хэлэлцүүлгийг зохион байгуулж, 335 иргэнийг оролцуулж санал авлаа. Төрийн зарим чиг үүргийн дагуу төрийн бус байгууллагуудаар 2019 онд гүйцэтгүүлэх 59 ажлын жагсаалтыг гарган танилцуулсан.	70

16		2.1.2. Зөвлөлдөх ардчиллын санал асуулгыг нэвтрүүлэн иргэдийг тэнцвэртэй, үнэн зөв мэдээллээр ханган, шийдвэр гаргах түвшний иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;	IV		Хэрэгжилтийг хангаж ажиллах	Хугацаа болоогүй.	ХТХБ
17	2.2. Төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх	2.2.1. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлэх, хяналт, хариуцлагыг сайжруулах;	IV		Төсвийн үр ашиг дээшилж, төсөв ил тод болно.	Шилэн дансны мэдээлэл байршуулалт, тайлан илгээлт 99 хувьтай байна. Аймгийн хэмжээнд төсөвт байгууллага 176, сан 3, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 2, хувийн өмчийн аж ахуйн нэгж 71, орон нутгийн аж ахуйн тооцоот байгууллага 4 нийт 256 байгууллагын шилэн дансны мэдээлэл байршуулсан байдалд хяналт тавьсан. Нийт 31859 мэдээлэл мэдээлсэн ба 5122 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэл байршуулалт хангалтгүй байна.	100
18		2.3.1. Төрийн үйлчилгээг иргэнд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, үйлчилгээний ажилтны чиг үүрэг, эрх хэмжээ, үйлчилгээ үзүүлэх хугацаа, бүрдүүлэх шаардлагатай материал зэрэг мэдээллийг нээлттэй хүргэж байх;	IV		Байгууллага бүр үйл ажиллагаандаа мөрдөгдөж байгаа мэдээллийг цахим хэлбэрт оруулсан байна	Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон шинээр мөрдөгдөж байгаа хуулиудыг онцлон иргэдэд ойлгомжтой хэлбэрээр танилцуулах шторк, слайдуудыг байршуулан ажиллаж байна. Аймгийн вэб сайтад иргэд ихээр үйлчлүүлдэг салбар болох <ul style="list-style-type: none"> • Улсын бүртгэл • Газрын харилцаа • Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар • Татвар, санхүү • Байгаль орчин, аялал жуулчлалын газар зэрэг 5 цэсийг вэб сайтын тусгай цэс болгон, үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчилж байна. 	70
19	2.3. Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх	2.3.2. Иргэн, хуулийн этгээдэд хэрэгцээтэй, тэдэнд хамаарах шийдвэрийг цахим хуудас болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлж хэвших;	IV		Хэрэгжилтийг хангаж ажиллах	Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон шинээр мөрдөгдөж байгаа хуулиудыг онцлон иргэдэд ойлгомжтой хэлбэрээр танилцуулах шторк, слайдуудыг байршуулан ажиллаж байна. Тухайлбал, 2018 онд www.legalinfo.mn сайтаас 16 холбоос, 24 танилцуулга шторкыг вэб сайтад байршуулан иргэдэд түгээсэн байна. Орон нутгийн телевизтэй хамтран “Хуулийн цаг” нэвтрүүлгийг 9 дугаар бэлтгэн хууль сахиулах байгууллагын ажилтнууд, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга мэргэжилтнүүдийг оролцуулан Монгол улсын хууль, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэр, журмын хэрэгжилт, шинэчлэлтийг тайлбарлан мэдээлж байна.	100

20		2.3.3. Иргэнээс гарах үйл ажиллагааны зардал, төрийн үйлчилгээ авах цаг хугацааг бууруулах зорилгоор шат дамжлагыг цөөлөх, үйл ажиллагааг оновчтой болгоход чиглэсэн дүрэм, журмыг хянан үзэж өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авах;	II		2012-2018 онд батлагдсан дүрэм, журмын холбогдох заалтыг хүчингүй болгох	Аймгийн ИТХ, тэргүүлэгчид, аймгийн Засаг даргаас 2012-2018 онд гаргасан шийдвэрүүдэд судалгаа хийж үзэхэд 123 шийдвэрт өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэн холбогдох байгууллагад санал авахаар хүргүүлээд байна.	30
21		2.3.4. Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь тухайн байгууллагын ажилтнуудад нээлттэй байх, шийдвэрийн үндэслэлийн талаарх мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд нээлттэй болгох.	IV		Хэрэгжилтийг хангаж ажиллах	2019 оны 1 дүгээр улирлын байдлаар аймгийн хэмжээнд эрх бүхий албан тушаалтнуудын гаргасан 135 захирамж, 57 тушаалын эрх зүйн үндэслэлийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс хянаж, холбогдох заавар, зөвлөмжийг өгсөн. Мөн гаргасан шийдвэрүүдээ тухай бүрт нь иргэдэд нээлттэй байдлаар цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэж байх талаар зөвлөгөө өгч ажиллаж байна.	30
22	2.4. Мэдээлэл хүргэх оновчтой тогтолцоог бий болгох	2.4.2. Төрийн байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх мэдээллийн системд танилт нэвтрэлтийн нэгдсэн ДАН системийг холбох;	II		10	Дан системийг нэвтрүүлэхээр судалгааны ажил хийж байна.	ХТХБ
3. ОНОВЧТОЙ ЧИГ ҮҮРЭГ							
23	3.2. Чиг үүргийн дахин хуваарилалтыг хийж, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох	3.2.1. Төвлөрлийг сааруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг дахин хуваарилах;	IV		Төрийн байгууллагын чиг үүрэг, хүлээх хариуцлага тодорхой болсон байна	Төрийн байгууллагын албан хаагчдад ажлын байрны шинжилгээ хийх сургалтыг зохион байгуулсан. Байгууллага бүр чиг үүргийн шинжилгээ хийж байна.	30

24		3.2.2. Орон нутгийн хөгжлийн загварт тулгуурлан нийгмийн үйлчилгээний жишиг нормативыг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй болгох.	IV		Хэрэгжилтийг хангаж ажиллах	Хугацаа болоогүй үнэлэх боломжгүй байна.	ХТХБ
4. ҮР ДҮНД СУУРИЛСАН УДИРДЛАГА							
25	4.1. Гүйцэтгэлийн үнэлгээгээр хувь хүний өрсөлдөх чадварыг хөхиүлэн дэмжих	4.1.1. Үр дүнд суурилсан удирдлагын хяналт, шинжилгээ, үнэлгээний системийг нэвтрүүлэх;	IV		Бодлого төлөвлөлт, төсөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөө нэмэгдсэн байна	Бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сум, байгууллагуудаас АБЛЕ программаар авч хэвшсэн. Ингэснээр мэдээ, тайлангууд цаг алдалгүй хугацаандаа ирж, түүний мөрөөр засаж сайжруулах зөвлөмжийг нэгж байгууллагад хүргүүлэн цаашдын үйл ажиллагаандаа тусгаж ажиллах нөхцөл бүрдсэн.	30
26	4.2. Гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулж, олон тулгуурт хяналтын тогтолцоог хөгжүүлэх	4.2.1. Төрийн байгууллагын үйл ажиллагааг бус үр дүнг үнэлдэг үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх; (иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг нэвтрүүлж төрийн бодлогын үр дүн, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг хараат бусаар үнэлж, дүгнэн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээ авч ажиллах соёлыг хэвшүүлэх)	IV	Засаг даргын нөөцийн хөрөнгө 7.7 сая	Хэрэгжилтийг хангаж ажиллах	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийн, цаашдын бодлого, төлөвлөгөөнд тусгах зорилгоор иргэдээс хэрэглэгчийн үнэлгээний судалгаа авах ажлыг зохион байгууллаа. Тус судалгааг "Булган Манлайлал-Шийдэл" төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэв. Судалгаанд 10 сумын 825 иргэн хамрагдсан бөгөөд хэрэглэгчийн үнэлгээ 2018 онд 53.0 хувьтай гарсан байна. Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үнэлгээний мөрөөр ажил сайжруулах төлөвлөгөө гарган ажиллалаа.	100
27		4.2.2. Иргэдийн сэтгэл ханамжийн үндэсний индекстэй болох;	III		"Иргэдийн сэтгэл ханамжийн индекс"-тэй болсон байна	Хугацаа болоогүй үнэлэх боломжгүй байна.	ХТХБ
28		4.2.3. Төрийн үйлчилгээнд иргэдийн үнэлгээний картын системийг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх.	IV		Хуулийн төслийг боловсруулах	Хугацаа болоогүй үнэлэх боломжгүй байна.	ХТХБ
5. ИРГЭН ТӨВТЭЙ МЭРГЭШСЭН ТӨРИЙН АЛБА							

29	5.1. Төрийн албаны хүний нөөцийн төлөвлөлтийг хөгжүүлж, сургалт хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх	5.1.1. Иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, үр чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг тууштай хэрэгжүүлэх;	IV		Төрийн албаны тухай хуулийн "Чадахуйн зарчим"-ыг хэрэгжүүлсэн байна	Хугацаа болоогүй үнэлэх боломжгүй байна.	ХТХБ
30		5.1.3. Төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн алба хаших шалгуур нь зөвхөн мэргэшлийн болон уг албыг гүйцэтгэх мэдлэг чадвар, мэргэжлийн ёс зүйгээр тодорхойлогддог байх нөхцөлийг бүрэн хангах;	IV		Аймгийн хэмжээнд ажиллаж буй 3873 төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг улирал тутам дүгнэж, мэргэшүүлэх, урамшуулах, хариуцлага үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна	Монгол улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг хэрэгжүүлэх талаар агентлаг, байгууллагуудад үүрэг өгөөд байна. Төрийн байгууллага, төрийн албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж байна.	ХТХБ
31	5.2. Цалин хөлс, урамшуулал, нийгмийн баталгаа	5.2.4. Төрийн албан хаагчийн орон сууцны хөтөлбөрийг баталж, орон сууцаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэх;	II		Төрийн албан хаагчдын орон сууцны нөхцөлийг тодорхойлсон байна.	Төрийн албан хаагчийн хүний нөөцийн системийн тайланд үндэслэн Булган аймгийн төрийн албан хаагчдын орон сууцны судалгааг урьдчилсан байдлаар гаргаад байна. Судалгаагаар нийт төрийн албан хаагчдын 21.9 хувь нь байранд, 66.2 хувь нь хашаа байшинд, 2.4 хувь нь гэрт, 5.1 хувь нь түрээсийн орон сууцанд, 4.1 хувь нь бусдын орон сууцанд амьдарч байна.	30
32	5.3. Ажлын байрны шинжилгээ, үнэлгээ	5.3.1. Ажлын байрны шинжилгээг хийж, тухайн ажлын байранд тавигдах шалгуурыг тодорхой тогтоох, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, цалин хөлсний системийг боловсронгуй болгох, ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлох, ажилтнуудын ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авах.	II		Төрийн жинхэнэ албаны 512, төрийн үйлчилгээний албаны 2800 албан тушаалд ажлын байрны шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан байна	Удирдлагын академитай хамтран "Ажлын байрны шинжилгээ хийх арга зүй" сургалтыг зохион байгуулж бүх шатны төрийн байгууллагын дарга, удирдах албан тушаалтан, дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан. Төрийн байгууллага бүр удирдлагын шийдвэрээр ажлын хэсгийг байгуулж, ажлын байрны шинжилгээ хийж эхлээд байна.	30
Нэгдсэн дүн							57.4